

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2015.03.02

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2015 онд 80 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 8 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 450 ХХК Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ББСБ-уудын тооны өөрчлөлтийг харуулбал:

Хүснэгт 1

д/д	Тайлант хугацаа	ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй	Гадаадын хөрөнгө оруулалттай	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 он	378	40	23	53
10	2015 он	450	50	27	52

ББСБ-ын тооны өөрчлөлтийг үзүүлбэл:

График 1



Хорооноос ББСБ-уудын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

д/д	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 он	120	5	5	1	378
10	2015 он	80	8	6	5	450

2015 онд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон 80 ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 30.6 тэрбум төгрөг байна.

Мөн онд Хорооны хуралдаанаар 6 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 8 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 5 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх арга хэмжээ авсан байна.

Хорооны хуралдаанаар зээлийн үйл ажиллагаа эрхлэх 2, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх 2, итгэлцэлийн үйлчилгээний эрхлэх 3, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ үйл ажиллагаа эрхлэх 3, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 7, факторингийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх 1 компанийн хүсэлтийг тус тус шийдвэрлэж, нэг компанийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх, мөн нэг компанийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгох арга хэмжээ авсан байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж байгаа байдлаар нь ББСБ-уудыг ангилвал:

д/д	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын давхардсан тоо ба өсөлт		Өсөлт/бууралт	
		2014.ҮҮ улирал	2015.ҮҮ улирал	тоо	хувь
	Нийт ББСБ	378	450	72	19.0
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг	129	136	7	5.4
	<i>Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг</i>	53	52	(1)	(1.9)
2	Зээл	323	380	57	17.6
3	Факторингийн үйлчилгээ	16	18	2	12.5
4	Төлбөрийн баталгаа гаргах	11	15	4	36.4
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0	-	-
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	6	-	100.0
7	Итгэлцлийн үйлчилгээ	24	26	2	8.3
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	-	100.0
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	29	27	(2)	(6.9)

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэхүү салбарт оролцогчдын тоо 19.0 хувиар буюу 72 компаниар нэмэгдэж, зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 17.6 хувь буюу 57 компаниар, гадаад валютын арилжаа эрхлэгчид 5,4 хувиар буюу 7 компаниар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэгчдийг тоо 36.4 хувиар буюу 4 компаниар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй 450 ББСБ-ын 30.2 хувь буюу 136 компани гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 11.5 хувь буюу 52 компани нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна.

Мөн нийт ББСБ-ын 84.4 хувь буюу 380 компани зээлийн үйл ажиллагаа, 6 хувь буюу 27 компани хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.8 хувь буюу 26 компани итгэлцлийн үйлчилгээ, 4 хувь буюу 18 компани факторингийн үйлчилгээ, 3.3 хувь буюу 15 компани төлбөрийн баталгаа гаргах, 1.3 хувь буюу 6 компани цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь буюу 2 компани богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Тайлант хугацаанд эхлэлтийн санхүүгийн тайлангаар 13 ББСБ, өмнөх үеүдийн санхүүгийн тайлангаар 14 ББСБ нэгтгэлд хамрагдсан байна.

2015 оны жилийн эцсийн тайлан ирүүлбэл зохих нийт 450 ББСБ-аас 423 ББСБ буюу 94.0 хувь нь тайлангаа зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж тайлангийн нэгтгэлд хамруулсан байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж харуулбал: Үүнд:

Хүснэгт 4

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны IY улирал	2015 оны IY улирал	Өсөлт бууралт	
				дүн	хувь
1	ББСБ-ын тоо	378	450	72	19,0
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	868	922	54	6,2
3	Ажиллагсадын тоо	1678	1,995	317	18,9
4	Салбар нэгжийн тоо	92	116	24	26,0
5	Харилцагчдын тоо	663,098	636,341	(26,757)	(4,0)
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	507,965,683.9	623,172,524.1	115.206.840.2	22,7
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>2.25%</i>	<i>3,01%</i>		<i>0.75%</i>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	303,132,859.4	391,235,479.1	88,102,618.7	29,1
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>2.44%</i>	<i>3.4%</i>		<i>0.96%</i>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	332,077,845.7	424,210,836.2	110,132,990.5	33,2
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>15.56%</i>	<i>16.78%</i>		<i>1.22%</i>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	258,197,982.6	308,451,260.0	50,253,277.4	19,5
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>65.56%</i>	<i>46.57%</i>		<i>(18.99%)</i>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	25,659,100.7	31,150,371.7	5,491,271.0	21,4
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	123,584,216.7	125,902,296.2	2,318,079.5	1,9
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/	60,276,951.3	63,613,263.1	3,336,311.8	5,5
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	63,307,265.5	62,289,033.1	(1,018,232.4)	(1.6)
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	12,502,932.8	14,956,721.2	2.45378864	19.6
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	132,909,005.8	156,102,780.9	23,193,775.1	17,4
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	96,548,372.7	109,715,271.9	13,166,899.2	13,6
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	36,360,633.1	46,387,509.0	10,026,875.9	27,6

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 623.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.01 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 391.2 тэрбум төгрөг байгаа нь банкны

салбарын мөн үзүүлэлтийн 3.4 хувьтай, эзэмшигчдийн өмч 424.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 16.78 хувьтай, дүрмийн сан 308.4 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 46.57 хувьтай тус тус тэнцэж байна.

ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 22,7 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд эзэмшигчдийн өмчийн дүн 110.1 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 50.2 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Мөн өр төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өр 5.5 тэрбум төгрөгөөр буюу 21.4 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 2.4 тэрбум төгрөгөөр буюу 19.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн эдгээр өөрчлөлт, өсөлттэй уялдан нийт зээлийн хэмжээ 88.1 тэрбум төгрөгөөр буюу 29.1 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 72 компаниар буюу 19.0 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 54-өөр буюу 6.2 хувиар нэмэгдсэн байна. Салбарт ажиллагсдын тоо 317 хүнээр нэмэгдэж 1995-д хүрсэн байна.

Улсын хэмжээнд 450 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.8 хувь буюу 400 нь УБ хотод, 11.1 хувь буюу 50 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Говь-Алтай, Увс аймгуудад ББСБ байгуулагдаагүй байна.

ББСБ-уудын байршлыг үзүүлбэл:

график 2



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

Тайлант улиралд орон нутагт төвтэй 50 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.1 хувийг, тэдгээрийн актив нь салбарын активын 2.7 хувийг, зээл нь 3.21 хувийг, эзэмшигчдийн өмч нь 3.2 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 5

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны IY улирал	2015 оны IY улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	40	50	10
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	10.58%	11,1%	0.52%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	11,227,752.5	16 622 688,8	5,394,936.3
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.21%	2.66%	0.45%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	8,766,732.6	12,561,732.7	3,795,000.1
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	2.89%	3.21%	0.32%
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр /2,1 1,9/	184,151.7	571,542.5	387,390.8
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь	2.1%	1.64%	0.54%

В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	9,673,465.5	13,580,419.4	3,906,953.9
<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>		<i>2.91%</i>	<i>3.20%</i>	<i>0.29%</i>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	6,680,951.8	8,391,032.4	1,710,080.6
<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>		<i>2.59%</i>	<i>2.72%</i>	<i>0.13%</i>
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	219,545.1	259,970.9	40,425.8
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	78,665.6	142,336.0	63,670.4
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	140,879.5	117,634.9	(23,244.6)
	Валютаар татсан зээл /мянган төгрөгөөр/	-	-	-
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	615,000.0	340,000.0	(275,000.0)
	Үүнээс: Валютаар /мянган төгрөгөөр/	-	-	-
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	2,693,345.9	9,088,428.4	6,395,082.5
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	1,198,491.7	2,013,534.6	815,042.9
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,494,854.2	2,657,405.9	1,162,551.7

2012 оны жилийн эцэст 24 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан бол 2013 оны жилийн эцэст 31, 2014 оны жилийн эцэст 40, 2015 жилийн эцэст 50 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж жил бүр 25-29 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тоо өсөлттэй байгаа боловч чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

Тайлант хугацааны эцэст гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 27 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 6 хувийг, тэдгээрийн актив нь ББСБ-ын нийт активын 15.5 хувийг, зээлийн үлдэгдэл нь нийт ББСБ-уудын зээлийн 18.4 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 13.3 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 13.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны ГҮ улирал	2015 оны ГҮ улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	23	27	4
<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>		<i>6.08%</i>	<i>6.0%</i>	<i>(0.08%)</i>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	66,757,988.4	96,636,673.1	29,878,684.7
<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>		<i>13.14%</i>	<i>15.50%</i>	<i>2.36%</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	42,034,697.3	72,099,576.3	30,064,879.0
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,748,267.5	8,166,114.7	5,417,847.2
<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		<i>13.87%</i>	<i>18.42%</i>	<i>4.55%</i>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	41,614,522.9	56,622,947.3	15,008,424.4
<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>		<i>12.53%</i>	<i>13.34%</i>	<i>0.81%</i>
Г	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	33,491,829.4	41,477,491.9	7,985,662.5
<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>		<i>12.97%</i>	<i>13.44%</i>	<i>0.47%</i>
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	16,694,854.1	27,180,123.0	10,485,268.9
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	7,280,689.4	13,163,907.9	5,883,218.5
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	9,414,164.7	14,016,215.0	4,602,050.3
	Валютаар татсан зээл /мянган төгрөгөөр/	2,205,690.6	546,984.6	(1,658,706.0)
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	4,451,200.0	5,028,220.8	577,020.8
	Үүнээс: Валютаар /мянган төгрөгөөр/	3,771,200.0	4,611,628.6	840,428.6
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	15,319,600.5	50,598,983.0	35,279,382.5
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	13,162,999.6	22,112,784.2	8,949,784.6
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	2,156,600.9	5,621,005.8	3,464,404.9

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, Хонгконгийн хөрөнгө оруулалттай 2, АНУ, ОХУ, Люксембург, Малайз, Англи, Франц, Швейцар, Хятад, Сичель улсын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Тайлант онд нийт 80 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосны 7.5 хувь буюу 6 компанид гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Мөн өмнө нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 6 компанид гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгосон ба гадаад валютын арилжаа тусгай зөвшөөрлийг нь сэргээсэн болон хүчингүй болгосон тус бүр 1 компани байна.

Тайлант хугацааны эцэст Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 450 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүний 29.3 хувь буюу 132 компани гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 11.5 хувь буюу 52 компани нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна.

Гадаад валютын арилжааг дагнан эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулвал:

Хүснэгт 7

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны IY улирал	2015 оны IY улирал	Өсөлт /+/, бууралт /-/ %
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	53	52	(1)
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>14,02%</i>	<i>11,55%</i>	<i>(2,47%)</i>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	9,979,396.9	11,173,674.2	1,194,277.3
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>1.97%</i>	<i>1,79%</i>	<i>(0.9%)</i>
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	9,921,734.4	10,817,889.5	896,155.1
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>1.96%</i>	<i>2,55%</i>	<i>0.59%</i>
В	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	8,347,742.4	9,277,550.0	929,807.6
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>3.23%</i>	<i>3,00%</i>	<i>(0.23%)</i>
В	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	-	-	-
Г	Нийт орлого /мянган төгрөгөөр/	1,452,307.8	1,380,732.5	(71,575.3)
Д	Нийт зардал /мянган төгрөгөөр/	1,381,507.7	1,175,658.3	(205,849.4)
Е	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	70,800.0	114,094.5	43,294.5

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант хугацааны ББСБ-уудын активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 8

д/д	ХӨРӨНГӨ	2014.12.31		2015.12.31		Өсөлт бууралт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
А	Эргэлтийн хөрөнгө	490,509,716.3	96.6	600,422,405.4	96.3	109,912,689.1	18.3
1	Мөнгөн хөрөнгө	155,975,027.9	30.8	174,217,117.5	28.2	18,242,089.6	10.5
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	11,012,313.7	2.2	11,856,047.3	1.9	843,733.6	7.1
3	Нийт зээл	303,132,859.4	59.8	391,235,479.1	62.8	88,102,619.7	22.5
	(Зээлийн эрсдийн сан)	15,171,481.7	3.0	26,556,625.7	4.3	11,385,144.0	42.9
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	-	-	-	-	-	-

	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	30,000.0	-	30,000,00	-	0.0	-
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	7,500.0	0.01	30,000,00	0.005	22 500,00	75.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1,308,692.6	0.3	2,726,025.7	0.4	1 417 333,08	52.0
7	Бусад хөрөнгө	34,229,804.5	6.7	46,944,361.5	7.5	12 714 556,99	27.1
Б	Эргэлтийн бус хөрөнгө /цэврээр/	17,455,967.6	3.4	22,750,118.7	3.7	5 294 151,06	23.3
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	17,455,967.6	3.4	28,541,236.3	4.6	11 085 268,66	38.8
	(Хуримтлагдсан элэгдэл)	4,781,609.7	0.9	5,791,117.6	0.9	1 009 507,90	17.4
НИЙТ ХӨРӨНГӨ		507,965,683.9	100.0	623,172,524.1	100.0	115 206 840,21	18.5


2014 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 378 ББСБ 507.9 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байсан ба активын өсөлт нь өмнөх оныхоо мөн үеэс 126.8 тэрбум төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн бол тайлант хугацаанд 450 ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 623.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 115.2 тэрбум төгрөгөөр буюу 18,5 хувиар өссөн байна.

Активын өөрчлөлт ба бүтцийг өмнөх онуудтай харьцуулж харуулбал:

График 3



График 4



3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 9

д/д	Ангилал	2014.12.31		2015.12.31		Өсөлт бууралт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	263,054,675.6	86.8	330,712,691.4	84.5	67,658,015.8	25.7
2	Хугацаа хэтэрсэн	20,832,093.5	6.9	22,198,319.8	5.7	1,366,226.3	6.5
3	Чанаргүй зээл. Үүнээс	19,246,090.3	6.3	38,324,467.8	9.8	19,078,377.5	99.1
	Хэвийн бус	4,587,472.3	1.5	10,904,597.0	2.8	6,317,124.7	137.7
	Эргэлзээтэй	5,925,205.9	2.0	10,632,114.9	2.7	4,706,909.0	79.4
	Муу	8,733,412.1	2.9	16,787,755.9	4.3	8,054,343.8	92.2
4	(Зээлийн эрсдэлийн сан)	15,171,481.7	5.0	26,556,625.6	6.8	11,385,143.9	75.0
Нийт зээл		303,132,859.4	100.0	391,235,479.1	100.0	88,102,619.7	29.1
5	Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл	272,415,550.4	89.9	352,096,434.0	90.0	79,680,883.6	29.2
6	Гадаад валютаар олгосон зээл	30,717,309.0	10.1	39,139,045.1	10.0	8,421,736.1	27.4

Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 88.1 тэрбум төгрөгөөр буюу 29.1 хувиар өссөн байна.

Зээлийн бүтцийн хувьд нийт зээлд төгрөгөөр олгосон зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өсч, гадаад валютаар олгосон зээлийн эзлэх хувь мөн хувиар буурсан байна. Төгрөгөөр олгосон зээл өмнөх оны мөн үеэс 79.7 тэрбум төгрөгөөр буюу 29.2 хувиар, гадаад валютаар олгосон зээл 8.4 тэрбум төгрөгөөр буюу 27.4 хувиар тус тус өссөн байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангилалын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдсэн, нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 19.1 тэрбум төгрөгөөр буюу 99.1 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 11.3 тэрбум төгрөгөөр буюу 75.0 хувиар өссөн байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

График 5





График 5.1




Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 395 ББСБ -ууд нийт 391,235 ,479.1 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 9.8 хувь нь буюу 38,324,467.8 мянган төгрөгийн чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл байна.

3.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 450 ББСБ-аас 87.8 хувь буюу 395 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээр компаниудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10.0 хувь, хамгийн бага хүү 0.1 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

График 6



3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Богино хугацаат хөрөнгө оруулалтын /цэврээр/ дансны үлдэгдэлд 11,856,047.3 мянган төгрөг байна. Үүнд:

Хүснэгт 10

д/д	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/	Богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	10,549,238.1	88.9
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1,306,809.2	11.1
3	Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, хямдруулалт	0.00	0,0
	НИЙТ	11,856,047.3	100,0

Факторингийн тооцооны авлагыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 11

д/д	ББСБ-ын нэр	Факторингийн тооцооны авлага /мян. төг/	(Факторингийн авлагын эрсдэлийн сан)
1	Монгол факторинг	30,000.0	(30,000.0)
	НИЙТ	30,000.0	(30,000.0)

Факторингийн тооцооны авлагын 100.0 хувь нь буюу 30,000.0 мянган төгрөг нь муу авлагад ангилагдан 30,000.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 450 ББСБ-д 28,541,236.3 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө бүртгэгдсэн ба тэдгээрт 5,791,117.6 мянган төгрөгийг хуримтлагдсан элэгдэл тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 12


д/д	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2014.12.31		2015.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
A	Нийт өр төлбөр	164,620,997.1	32.4	175,628,423.0	28.2	11,007,425.9	6.7
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	25,659,100.7	5.1	31,150,371.7	5.0	5,491,271.0	21.4
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	123,584,216.7	24.3	125,902,296.2	20.2	2,318,079.5	1.9
3	Бусад эх үүсвэр	1,889,346.9	0.4	3,103,234.8	0.5	1,213,887.9	64.2
	<i>Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр</i>	82,646.2	0.02	0.0	0.0	(82,646.2)	(100.0)
	<i>Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг</i>	1,805,168.3	0.4	398,896.8	0.1	(1,406,271.5)	(7.9)
	<i>Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг</i>	1,532.4	0.0	2,704,338.0	0.4	2,702,805.6	176.3
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	985,400.0	0.2	515,799.0	0.1	(469,601.0)	(47.7)
5	Төслийн зээлийн санхүүжилт	12,502,932.7	2.5	14,956,721.2	2.4	2,453,788.5	19.6
6	Бусад өр төлбөр	11,266,841.1	2.2	23,333,264.9	3.7	12,066,423.8	107.1

	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,227,695.1	0.6	4,927,856.8	0.8	1,650,161.7	51.1
	Бусад пассив	8,039,146.0	1.6	18,405,408.1	3.0	10,366,262.1	128.9
	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	-	-	-	-	-	-
Б	Эзэмшигчдийн өмч	332,077,845.7	65.4	424,210,836.2	68.1	92,132,990.5	27.7
7	Хувьцаат капитал	258,197,982.6	50.8	308,451,260.0	49.5	50,253,277.4	19.5
8	Бусад өмч	7,202,941.7	1.4	12,015,216.9	1.9	4,812,275.2	66.8
9	Сангууд	255,717.7	0.1	330,776.8	0.1	75,059.1	29.3
10	Хуримтлагдсан ашиг/алдагдал	64,028,518.3	12.6	102,012,229.2	1.4	37,983,710.9	59.3
11	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,392,685.5	0.5	1,401,353.2	0.2	(991,332.3)	(41.4)
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	507,965,683.9	100.0	623,172,524.1	100.0	115,206,840.2	22.7

2014 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 378 ББСБ-ийн хөрөнгийн эх үүсвэр 507,9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоо мөн үеэс 126,8 тэрбум төгрөгөөр буюу 33.3 хувиар өсч байсан бол тайлант хугацаанд 450 ББСБ-уудын хөрөнгийн эх үүсвэр 623.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 115,2 тэрбум төгрөгөөр буюу 22,7 хувиар өссөн байна.


ББСБ-уудын системийн нийт пассивын хэмжээг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 7



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын төслийн зээлийн санхүүжилтийн хэмжээ 19,6 хувиар, итгэлцэлийн үйлчилгээний өглөг 21.4 хувиар, бусад эх үүсвэр 64.2 хувиар, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 176.3 хувиар тус тус өсч, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 1.9 хувиар буурсан байна.

График 8



2015 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 27 ББСБ байгаагаас нэр бүхий 3 компани өмнөх оны мөн үеийн адил итгэлцлийн үйлчилгээний өргүй байна.

Бусад нэр бүхий 23 ББСБ 31,150,371.7 мянган төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын өр төлбөрийн 15.6 хувьтай тэнцэж байна.

Нийт ББСБ-ын 5.8 хувийг эзлэх эдгээр 27 компанийн актив нь салбарын нийт активын 37.7 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь салбарын нийт эзэмшигчийн өмчийн 28.6 хувийг тус тус эзэлж байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ байгаагаас 3 компани өмнөх оны мөн үеийн адил мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өргүй байна. Бусад 2 ББСБ нь 398,896.8 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртэй байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ-ын актив 21,975,653.5 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 3.5 хувийг, эзэмшигчийн өмчийн дүн 15,568,414.3 мянган төгрөг байгаа нь салбарын мөн үзүүлэлтийн 3.7 хувийг, Төлбөр тооцооны үйлчилгээний өр 2,704,338.0 мянган төгрөг нь салбарын нийт өрийн 1.3 хувьтай тэнцэж байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөр 3 ББСБ нийт 515,799.0 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргасан байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар 8 ББСБ 1,401,353.2 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант улиралд ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

Хүснэгт 13

д/д	Үзүүлэлт	2014.12.31		2015.12.31		Өсөлт бууралт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Хүүгийн орлого	89,860,191.3	67.6	119,770,174.9	76.7	29,909,983.6	33.3
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	86,932,735.1	65.4	116,081,801.0	74.4	29,149,065.9	33.5
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	2,117,758.5	1.6	2,950,597.2	1.9	832,838.7	39.3
	Үнэт цаасны хүүгийн орлого	-	-	20,291.3	0.0	20,291.3	100.0
	Бусад хүүгийн орлого	809,744.4	0.6	717,485.4	0.5	(92,259.0)	(11.4)
2	Хүүгийн бус орлого	41,620,140.3	31.3	33,373,031.9	21.4	(8,247,108.4)	(19.8)
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,288,052.6	1.0	2,959,574.1	1.9	1,671,521.5	129.8
4	Ердийн бус орлого	88,334.6	0.1	-	-	-	-
	Нийт орлого	132,856,718.8	100.0	156,102,780.9	100.0	23,246,062.2	17.5

Тайлант хугацааны нийт орлогын 76.7 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 33.3 хувиар өссөн/, 21.4 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 19.8 дахин өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого дараах үндсэн бүтэцтэй байна.

д/д	Үзүүлэлт	2014.12.30		2015.12.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Арилжааны орлого	4,083,921.3	9.8	3,011,596.3	9,0	(1,072,325.0)	(26.3)
1.1	Гадаад валютын арилжааны орлого	4,083,921.3	9.8	3,011,596.3	9,0	(1,072,325.0)	(26.3)
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	820.0	0.0	0.0	-	(820.0)	(100.0)
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	29,934,236.1	71.8	23,517,647.4	70,5	(6,416,588.7)	(21.4)
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	28,465,730.8	68.3	23,517,647.4	70,5	(4,948,083.4)	(17.4)
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,468,505.3	3.5	0.0	-	(1,468,505.3)	(100.0)
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	7,654,267.8	18.4	6,843,788.2	20,5	(810,479.6)	(10.6)
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	1,051.6	0.0	0.0	-	(1,051.6)	(100.0)
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	8,077.2	0.0	3,120.1	0,01	(4,957.1)	(61.4)
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	865,215.3	2.1	631,262.0	1,9	(233,953.3)	(27.0)
3.4	Картын үйлчилгээний орлого	1,520.0	0.0	0.0	-	(1,520.0)	(100.0)
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	720,531.4	1.7	781,965.1	2,3	61,433.7	(8.5)
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	5,423,994.2	13.0	4,472,814.5	13,4	(951,179.7)	(17.5)
3.7	Бусад	633,878.2	1.5	954,626.5	2,9	320 748,4	(50.6)
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	41,672,425.3	100.0	33,373,031.9	100,0	(24 899 000,2)	(1.6)

2014 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 71.8 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол тайлант улиралд нийт хүүгийн бус орлогын 9.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 70.5 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 20.5 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

д/д	Үзүүлэлт	2014.12.31		2015.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Хүүгийн зардал	12,882,564.2	13.3	14 931 386,0	13.6	2,048,821.8	15.9
2	Хүүгийн бус зардал	66,731,273.9	69.1	71 268 197,9	65.0	4,536,924.1	6.8
3	Болзошгүй эрсдэлийн зардал	11,380,864.1	11.8	16 433 280,6	15.0	5,052,416.5	44.4
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,006,121.1	1.0	940 463,1	0.9	(65,658.0)	(6.5)
5	Ердийн бус зардал	8,491.2	0.0	-	-	(8,491.2)	(100.0)
6	Орлогын татварын зардал	4,539,058.3	4.7	6 141 944,3	5.6	1,602,886.0	35.3
	НИЙТ ЗАРДАЛ	96,548,372.8	100.0	109 715 271,9	100.0	13,166,899.1	13.8

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар, үүний дотор хүүгийн зардал 15.9 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 44.4 хувиар, орлогын татварын зардал 35.3 хувиар тус тус өсөж, үндсэн бус үйл ажиллагааны зардал 6.5 хувиар, хүүгийн бус зардал 6.8 хувиар, ердийн бус зардал 100.0 хувиар тус тус буурсан байна.


Тайлант хугацаанд нийт 46,387,509.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 16

д/д	Үзүүлэлт	2014.12.31	2015.12.31	Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Нийт орлого	132,909,005.8	156,102,780.9	23,246,062.2	17.5
2	Нийт зардал	96,548,372.7	109,715,271.	13,166,899.1	13.8
	Татварын дараах цэвэр ашиг	36,360,633.1	46,387,509.0	10,026,875.9	27,6

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж харуулбал:

График 9



ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл активтай, 1.0 тэрбум төгрөгөөс 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай, 5.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан тооцов. 2015 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

Хүснэгт 17

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	21	295,472,527.4	47.1%	5.0 тэрбум төгрөгнөөс дээш активтай

2	Бүлэг 02	93	183,221,778.6	29.4%	1.0 тэрбумаас 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай
3	Бүлэг 03	229	127,747,156.4	20.5%	400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай
4	Бүлэг 04	107	16,731,061.7	2.7%	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
НИЙТ					

2015 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Хүснэгт 18

№	Үзүүлэлтүүд	Бүлэг 01	Бүлэг 02	Бүлэг 03	Бүлэг 04	НИЙТ
1	Нийт актив /мянган төгрөг/	295 472 527.4	183,221 778.6	127 747,156.4	623 172 524.1	623 172 524.1
	ББСБ-уудын нийт активт эзлэх хувь	47.4	29.4	20.5	2.7	100.0
2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөг/	184,284,442.5	124,241,976.6	78,291,463.1	4,417,596.9	391,235,479.1
	ББСБ-уудын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	47.1	31.8	20.0	1.1	100.0
3	Нийт өр төлбөр /мянган төгрөг/	141,947,650.1	31,143,422.9	2,413,960.0	123,389.9	175,628,423.0
	ББСБ-уудын нийт өр төлбөрт эзлэх хувь	80.8	17.7	1.4	0.1	100.0
4	Эзэмшигчдийн өмч /мянган төгрөг/	137,650,740.0	147,355,457.8	122,814,585.8	16,390,052.7	424,210,836.2
	ББСБ-уудын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	32.4	34.7	29.0	3.9	100.0
5	Хувьцаат капитал /мянган төгрөг/	74,051,979.2	116,132,552.3	102,533,871.1	15,732,857.4	308,451,260.0
	ББСБ-уудын нийт хувьцаат капиталд эзлэх хувь	24.0	37.7	33.2	5.1	100.0
6	Хуримтлагдсан ашиг, алдагдал /мянган төгрөг/	55,107,476.1	28,880,658.9	17,575,074.5	449,019.7	102,012,229.2
	Салбарын нийт хуримтлагдсан ашигт эзлэх хувь	54.0	28.3	17.2	0.4	100.0
7	Тайлант үеийн цэвэр ашиг /мянган төгрөг/	22,099,106.3	15,218,424.9	8,878,776.7	191,201.1	46,387,509.0
	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хувь	47.6	31.8	19.1	0.4	100.0

2015 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 450 ББСБ-ын 4,6 хувийг 5.0 тэрбумаас дээш актив хөрөнгөтэй 21 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 47.4 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 47.1 хувь, нийт өр төлбөрийн 80.8 хувь, эзэмшигчдийн өмчийн 32.4 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 24.0 хувь, хуримтлагдсан ашгийн 54.0 хувь, тайлант хугацаанд үүссэн цэвэр ашгийн 47.6 хувийг тус тус эзэлж байна.

Харин нийт ББСБ-уудын 23.8 хувийг 400.0 сая төгрөг хүртэл актив хөрөнгөтэй 107 ББСБ эзэлж байгаа ба тэдгээр нь нийт ББСБ-уудын активын 2.7 хувь, зээлийн өрийн үлдэгдлийн 1.1 хувь, нийт өр төлбөрийн 0.1 хувь, эзэмшигчдийн өмчийн 3.9 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 5.1 хувийг бүрдүүлж байна.

2015 оны жилийн эцэст салбарын хэмжээгээр 5,271,472.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд алдагдалтай ажилласан ББСБ-уудын судалгаа /хавсралт-2/-г бүлэглэлтийн судалгаатай харьцуулахад алдагдалтай ажилласан ББСБ-уудын 43.4 хувийг 400.0 хүртэл сая төгрөгийн актив хөрөнгөтэй ББСБ-ууд эзэлж байх ба салбарын нийт алдагдал тухайн бүлэгт хамрагдаж байна.

ББСБ-уудыг бүлэглэсэн дээрх судалгаанаас харахад 5.0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж буй 21 ББСБ нь тухайн салбарын санхүүгийн гол үзүүлэлтүүдийн 24.0-80.8 хувийг дангаараа бүрдүүлж байна. /5.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний актив хөрөнгөтэй ББСБ-уудын санхүүгийн мэдээллийг нэгтгэлийн танилцуулгын хавсралт 5-д/.

ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант улиралд Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

Хүснэгт 19

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	330	73.33%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	90	20.00%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	18	4.00%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	9	2.00%
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.44%
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.22%
	НИЙТ	450	100.0%

Мөн ББСБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- Нийт өөрийн хөрөнгө 424,210,836.2 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 491,821,452.9 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 86,1 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 87.1 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 69,6 хувиар;

- Нийт түргэн борлогдох актив 122,634,375.7 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 85,847,757.2 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 108.0 хувиар;

- Валютын дансны цэвэр зөрүү 9,598,370.7 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 427,606,130.5 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 2.24 хувиар;

- Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 31,217,038.4 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 427,932,552.5 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 80 хувиас ихгүй байх шаардлага 7,3 хувиар;

-Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 9,372,850.5 мянган төгрөг, нийт актив 623,172,524.1 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 1.5 хувиар;

-Гаргасан хаалттай өрийн бичгийн үлдэгдэл 515,99.0 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 425,684,017.8 мянган төгрөг байгаагаас хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 50 хувиас ихгүй байх шаардлага 50 хувиар тус тус биелэсэн;

Харин зээлийн эрсдэлийн санг 26,556,625.7 мянган төгрөгөөр байгуулсан байна.

НАЙМ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 450 ББСБ-ын 67.4 хувь буюу 256 ББСБ энэ үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-д заасны дагуу нийт ББСБ-ын 98.0 хувь буюу 441 ББСБ дээрх хуулийн хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилон ажиллуулж байна.

3. Энэ онд нийт 350 ББСБ-аа 350,365.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 313 ББСБ 310 447,0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн. Биелэлт 88.6 хувьтай байна.

4. Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг оны эхэнд үйл ажиллагаа эрхэлж байсан 378 ББСБ -ын 56,6 хувь буюу 214 ББСБ хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.

ЕС. ДҮГНЭЛТ

1. 2015 онд нийт ББСБ-ын 94.0 хувь буюу 423 ББСБ санхүүгийн тайлангаа ирүүлж нэгтгэлд хамруулсан ба нэр бүхий 13 ББСБ эхлэлийн тайлан тэнцлийн, 14 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлийн үзүүлэлтээр хамрагдсан байна.

2. Тайлант хугацаанд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 72 компаниар буюу 19.0 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 54-өөр буюу 6.0 хувиар нэмэгдсэн байна. Салбарт ажиллагсдын тоо 317 хүнээр нэмэгдэж 1995-д хүрч, харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 26.757-оор буюу 4.0 хувиар буурсан байна.

3. Улсын хэмжээнд 450 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.9 хувь буюу 400 нь УБ хотод, 11.1 хувь буюу 50 нь Говь-Алтай, Увс, аймгуудаас бусад орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

4. Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 623.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.01 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 391.2 тэрбум төгрөг байгаа нь

банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.4 хувьтай, эзэмшигчдийн өмч 424.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 16.8 хувьтай, дүрмийн сан 308.4 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 46.6 хувьтай тус тус тэнцэж байна.

5. ББСБ-уудын зарим үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 115.2 тэрбум төгрөгөөр буюу 22.7 хувиар, нийт активт эзлэх зээлийн хэмжээ 88.1 тэрбум төгрөгөөр буюу 29.1 хувиар, эзэмшигчдийн өмч 110.1 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 50.2 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар тус тус өссөн байна.

6. ББСБ-уудын өр төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өр 5.5 тэрбум төгрөгөөр буюу 21.4 хувиар, банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн өр 2.3 тэрбум төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

7. Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 88.1 тэрбум төгрөгөөр буюу 29.1 хувиар өссөн боловч чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулвал 19.1 тэрбум төгрөгөөр буюу 99.1 хувиар өссөн байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангилалын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдэж, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин буюу 8.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой зээлийн эрсдэлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 11.3 тэрбум төгрөгөөр буюу 75.0 хувиар өссөн байна.

Нийт 391.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагийн 90.0 хувь нь төгрөгийн, 10.0 хувь нь гадаад валютын зээл байна.

8. ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 46,387,509.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.0 тэрбум төгрөгөөр буюу 27.6 хувиар өссөн байна. Нийт ББСБ-ын 76.0 хувь буюу 342 ББСБ 51,658,961.3 мянган төгрөгийн ашигтай, 16.9 хувь буюу 76 ББСБ 5,271,472.3 мянган төгрөгийн алдагдалтай, 7.1 хувь буюу 32 ББСБ ашиг, алдагдалгүй ажилласан байна.

9. ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал нэг дахин буюу ББСБ-ын дундаж хүү 3,8 хувьтай байгаа нь салбарын хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Иймд зохицуулалтын газрын зүгээс зээлийн хүү, эх үүсвэрийн өртөгийг бууруулах, зээлийн хүү тооцох аргачлал, журам боловсруулах чиглэлээр судалж, холбогдох санал дүгнэлтийг боловсруулж ажиллахаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаад байна.

АРАВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Зээлийн барьцаа хөрөнгө болон 90хоногоос дээш хуримтлагдсан зээлийн хүү балансын гадуур бүртгэгдэхгүй байгаа тул ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн зааврын дагуу холбогдох бүртгэлийг хийх.

2. Ангилал буурч байгаа зээлийн хувьд валютын зээлийн эзлэх хувь өсч байгаа тул валютын зээл өндөртэй байгаа ББСБ-дад анхаарч ажиллах.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР